

АГУУЛГА

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	2
1.2 Төслийн талбайн байршил	2
1.3 Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим	3
1.4 Уурхай болон баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжууд, үндсэн тоног төхөөрөмж, дэд бүтэц:	4
1.5 Хаягдлын байгууламж:	6
1.6. 2024 оны Баяжуулах үйлдвэрийн ашиглалтын ажлын төлөвлөгөө	8
БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
1.1. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал:	8
1.2. Байгаль орчны төлөв байдал:	8
БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
БҮЛЭГ IV. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	16
БҮЛЭГ V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
БҮЛЭГ X. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	30
БҮЛЭГ XI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	34
БҮЛЭГ XII. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	36
БҮЛЭГ XIII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН	36
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	39
БҮЛЭГ XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	41

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл


Төслийн нэр:	“Дожир нэртэй хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн Баяжуулах үйлдвэр
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж, байгууллагын нэр:	“Ханшашир” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9019058081 Регистрийн дугаар: 2618176
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 3 оргил хотхон 62-1 тоот
Байршил:	Хэнтий аймгийн Баян-Овоо сумын 2-р баг
Утас:	+976-86089010, +976-99055718
Мэйл хаяг:	khoroogerelmaa@gmail.com
Төслийн зорилго:	Хэнтий аймгийн Баян-Овоо суманд орших “Дожир” нэртэй MV-017305, MV-016819 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Ханшашир” ХХК-д АМГТГ-аас 2014 оны 11-р сарын 25-ны өдөр олгосон. “Ханшашир” ХХК нь “Дожир” нэртэй хайлуур жоншны ордыг түшиглэн байгуулсан баяжуулах үйлдвэр ажиллуулж орон нутгийн нийгэм, эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулсан компани болохоор зорин ажиллаж байна.
Тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-016819
Талбайн хэмжээ:	98.37 гектар

1.2 Төслийн талбайн байршил

Ашиглалтын талбай нь Хэнтий аймгийн Баян-Овоо сумын 2-р багийн нутаг дэвсгэрт харьяалагддаг ба Улаанбаатар хотоос зүүн зүгт 420 км, Хэнтий аймгийн төв Чингис хотоос 100 км, Баян-Овоо сумын төвөөс баруун зүгт 25 км-т байрладаг.

Хүснэгт 1. Ашиглалтын талбайн солбицол

Тусгай зөвшөөрлийн дугаар	Хүчинтэй (он/сар/өдөр)	Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
			градус	минут	секунд	градус	минут	секунд
МУ-016819	2016-07-01 ээс 2046-07-01 хүртэл	1	111	47	51.00	47	44	12.00
		2	111	47	00.00	47	44	12.00
		3	111	47	00.00	47	44	42.00
		4	111	47	51.00	47	44	42.00



Зураг 1 “Дожир уурхай”-н баяжуулах үйлдвэрийн байршлын зураг

1.3 Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим

“Ханшашир” ХХК-ийн жоншны баяжуулах үйлдвэр нь жоншны хүдрийн физик хими шинж буюу эрдсийн гадаргуу усанд “норох ба үл норох” чанарт үндэслэгдсэн флотацийн аргаар баяжуулагдана. Энэ технологи нь нарийн нунтаглагдсан хүдрийг урвалжийн тусламжтайгаар хөөсрүүлэлт үүсгэн ашигт эрдсийг хөөсөнд наалдуулан ялган авч хоосон чулуулгийг машины камерт үлдээж ялгах зарчимд тулгуурлана.

Баяжуулах үйлдвэр нь ашиглалтын лицензтэй, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй талбайгаасаа хүдрээ хангана. Буталсан хүдэр бункерээс туузан дамжуулагчаар бөмбөлөгт тээрэмд орж, 65-85% нь 200 меш болтол нунтаглагдсаны дараа хөвүүлэн баяжуулалтад орно. Жоншны хүдэр

баяжуулах технологид техникийн сод, шингэн шил, олеат натри, нарсны тос зэрэг урвалжуудыг ашиглана.

Тус жоншны баяжуулах үйлдвэрт жилд 38.58% дундаж агуулгатай 50000 тн жоншны хүдрийг флотацийн баяжуулалтаар 95.77%-ийн агуулгатай 21800 тн баяжмал авч 4.7%-ийн агуулгатай 28200 тн хаягдал ялгана.

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь дараах шат дамжлагуудаас бүрдэнэ.

Үүнд: Хүдэр баяжуулалтад бэлтгэх хэсэг

Нунтаглан баяжуулах хэсэг

Урвалжийн хэсэг

Шүүн хатаах, савлах хэсэг зэрэг технологийн үндсэн шат дамжлагуудаас бүрдэнэ.

Баяжуулах үйлдвэр нь жилд хавар 4 сарын 1-ээс өвөл 10 сарын 17 хүртэл тасралтгүй 166 хоног ажиллах бөгөөд 2 ээлж 12 цагаар ажиллана. Бусад үед нь засвар үйлчилгээ хийнэ.

1.4 Уурхай болон баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжууд, үндсэн тоног төхөөрөмж, дэд бүтэц:

Баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжууд, дэд бүтэц:

Баяжмалын агуулах, автомашинд ачааллах систем

Нунтаг баяжмалыг савлан баяжуулах үйлдвэрээс авто машинаар цементэлж бэлдсэн баяжмалын ил агуулахын төвд тээвэрлэнэ.

Баяжуулах үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүний агуулахууд нь ил талбайд хадгалагдах бөгөөд байгаль орчинд үүсэх тоосжилтоос сэргийлэх үүднээс өндөр төмөр хашаагаар хүрээлэгдсэн байна.

Засвар үйлчилгээний хэсэг

Засвар үйлчилгээний хэсэгт ЖБҮ-ийн тоног төхөөрөмжүүдэд төлөвлөгөөний дагуу ээлжит засвар үйлчилгээ хийхийн зэрэгцээ шинээр тоног төхөөрөмж угсрах, аваарын үед шаардлагатай засвар үйлчилгээ гүйцэтгэнэ. Засвар үйлчилгээний хэсэг нь 9х38м талбайтай, 5м өндөртэй, өргөх кранаар хангагдсан байна. Механик, цахилгааны төхөөрөмжийн засварын хэсэг болон өргөн хэрэглээний засварын 2 албатайгаар зохион байгуулна. Эдгээр өрөөний шал нь бетон цутгамал байна.

Удирдлагын өрөө

Баяжуулах үйлдвэрийн удирдлагын өрөө дараах тоног төхөөрөмжөөс бүрдэнэ.

- Хөдөлгүүрийн хяналтын хэсэг
- Гал илрүүлэгч болон заагч хэсэг
- Хяналтын системийн хэсэг
- Шилэн кабелийн холболтын хэсэг
- Телефон утасны хуваарилах хэсэг

ЖБҮ-ийн удирдлагын өрөө нь угсармал хэв маягтай зөөврийн буюу хөдөлгөөнгүй бэхэлсэн барилга байгууламж байж болно. Удирдлагын өрөө нь битүүмжлэгдсэн байх ба байшинд нэвтрэн орох тоосжилтын хэмжээг бууруулах салаалсан агаар шүүгчтэй байна.

Салаалсан агаар шүүгчийн нэгжүүд нь өрөөний дотоод температурыг 25°C-ээс доош байлгах үүрэгтэй. Доод хэсэгт кабелийг хүргэх үүднээс удирдлагын өрөөний зөөврийн танхимууд нь ган биет бүтцээр газрын түвшнээс доод тал нь 2.1м өндөрт өргөгдсөн байна. Удирдлагын өрөө нь тоног төхөөрөмжийн хэсэгт нэвтрэх давхар хаалга, ажиллагсад нэвтрэх дан хаалга бүхий 2 хаалгатай байна.

Цахилгаан хангамж: Цахилгаан эрчим хүчний хэрэгцээг Батноров 35/10 кВ дэд станцаас салбарлуулан 31 км агаарын шугам татаж төслийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдэх боломжтой гэж үзэж байна. Шугамын төгсгөлд 10/0.4 кВ-ын дэд өртөө угсран ашиглалтанд оруулна.

Харилцаа холбоо ба мэдээллийн хангамж: Дотоод кабель холболт, телефон утасны гарцыг ЖБҮ-ийн хөдөлгүүрийн удирдлагын төвийн өрөө бүрд суурилуулна (үүнд зорчих машин механизмыг

оруулахгүй). Хуваарилах байгууламжийн хяналт, мэдээллийн системд зориулан дотуур холбоог шилэн кабелиар холбоно. Талбайн хэмжээнд олон улсын холбоо харилцаанд шилэн кабель ашиглаж байгаа тохиолдолд доод тал нь 24 гол кабелийг холбоно. Тоног төхөөрөмжийн бие даасан хэсгүүдэд холбогдох бие даасан кабелиуд нь 2 жилийн нөөц буюу 20% нөөцтэй байна.

Хяналтын кабелийн систем: Үйлдвэрийн үйл ажиллагааг алсаас хянах үүднээс CCTV системийг суурилуулна. PC-д суурилсан системээр камеруудыг хянана. Камераас хяналтын өрөө хүртэлх холболтыг шилэн кабелиар хийнэ. Дижитал юм уу аналог камер байж болно. Камер нь IP хаяг оноож болохуйц байх ба дотоод сүлжээгээр харилцана.

Хяналтын системийн гэрэлтүүлэг хангалттай гэрэлтүүлэг үүсгэж чадахгүй бол харагдацыг өдрийн цагийн харагдацаар хязгаарлана. Нэрлэсэн байршил нь:

- | | |
|-----------------------------------|---|
| ✓ Нүүрс хүлээн авах бункерт | 1 |
| ✓ НБҮ-ийн үндсэн процессын хэсэгт | 2 |
| ✓ Хаягдлын бункерт | 1 |
| ✓ Овоолгын зөөврийн машинд | 1 |
| ✓ Бункераас ачаа зөөх хэсэг | 2 |

Усан хангамж: Ажилчдын унд ахуй, баяжуулах үйлдвэр болон нөхөн сэргээлтэд ашиглах усыг тус “Ханшашир” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайн баруун урд хэсэгт байрлах өөрийн эзэмшлийн гүний худгаас (Худгийн байршил /111⁰47/13// 47⁰44/16 ундрага 6.5 л/сек) авч ашиглана. Унд ахуй, баяжуулах үйлдвэр болон нөхөн сэргээлтэд шаардлагатай тохиолдолд зам усалгаанд ус хэрэглэхээр тооцсон. Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээг өөрийн эзэмшлийн гүний худгаас зөөвөрлөн ашиглах бөгөөд 80 хувийг эргүүлэн ашиглах, 20 хувийг нөхөн сэлбэлтээр ашиглана.



Зураг 2. Дэд станц

Үндсэн тоног төхөөрөмж:

Хүснэгт 2. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн нэгдсэн хүснэгт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Марк	Нийт хүчин чадал, кВт/ц
Бутлах цех				
1	Шигшүүр	1	Гулдмайт	-
2	Бункер	1	V=17 м3	-
3	Тэжээгүүр	1	GZG900*1800	1.1
4	Хацарт бутлуур	1	PEF400*600	30
5	Хацарт бутлуур	1	PEX150*750	15*2
6	Конвейер	1	B650, L=30	5.5
7	Шигшүүр	1	SZ1250*2500	5.5
8	Конвейер	1	B650, L=30	5.5
9	Металл мэдрэгч	1	RCYQ-6	4
10	Конвейер	1	B500, L=40	5.5
11	Кран	1	LDA-5T, L=7.95, H=8	8
12	Конвейер	1		2.2
Баяжуулах цех				
13	Бөмбөлөгт тээрэм	1	GM2100*3600	210
14	Мушгиа ангилуур	2	FLG2000	15
15	Ган	2	RJ20	5.5*2
16	Ган	2	RJ15	5.5*2
17	Флотмашин	18	SF-4	15*18
18	Флотмашин	13	SF-2.8	11*13
19	Насос	2	GMZ80-30-80	2*18.5
Шүүн хатаах цех				
20	Насос	2	80YZ80-20	2*11
21	Өтгөрүүлэгч	2	NZ-12	3*2
22	Вакум шүүлтүүр	1	GW-20	5.5
23	Кран	1	LDA-5T, L=12.95, H=7	8
24	Уурын зуух	1	1.4MW	1.5
25	Насос	2	3*3D-НН	7.5*2
26	Насос	2	ISG80-160A	11*2
27	Насос	1	WQ50-15-15	1.5
28	Хатаах зуух	1	1600*10000	7.5
29	Шурган дамжуулагч	1	300*10000	
30	Савлах машин	1	QLTD3(1-2)	2.2
31	Тэжээгч	1	DZ-4	3

Шинжилгээний лаборатори: Уг үйлдвэр нь тэжээлийн хүдэр ба технологийн процессуудын хяналт, бэлэн бүтээгдэхүүний чанарын хяналтыг шинжилгээний лабораторид гүйцэтгэх бөгөөд ээлж бүрд сорьцлолт гүйцэтгэж, шинжилгээ хийснээр үйлдвэрлэлийн процессуудыг тухай бүрд нь оновчлох нөхцөлөөр хангагдах юм. Лабораторид аналитик жин, хатаах шүүгээ, шатаах зуух, калориметр, химийн шилэн савнууд зэрэг техник тоног төхөөрөмж бүрэн тоноглогдоно. Лабораторид CaF₂, CaCO₃, SiO₂, SO₃, P₂, O₂ ба бусад элементүүдийг ээлжийнлаборантууд 24 цагт шинжилгээ хийж үзүүлэлтүүдээ тодорхойлно.

1.5 Хаягдлын байгууламж:

Баяжуулах үйлдвэр нь нийт ажиллах хугацаандаа 199757.6 тн хүдэр баяжуулах ба хаягдлын санд 122884.46 тн 45512.76 м³ хаягдал хаягдана. Жилд 11392 м³ 2-р шатны хяналтын флотацийн хаягдал хаягдлын санд орохоор эзлэхүүнийг тооцоолсон ба далангийн өндөр 5-8 м байна.

Далан нь ойр орчимд элбэг тааралдах материал болох элс хайрга шавраар бүрдсэн овоолго барих ба хаягдлын сангийн дотор талбайг HDPE геомембрамаар доторлоно. Далангийн бусад хэсгийг хайрга болон зориулалтын материалаар бэхжүүлнэ.

Тус үйлдвэрийн хаягдал агуулах сан нь булинга хуримтлуулах 1 ба 2-р сан болон эргэлтийн усан сангуудаас бүрдэнэ. Булинга хуримтлуулах 1-р сангийн ус шүүрүүлэх хэсгээр усыг цэвэршүүлэн хуримтлуулах 2-р цөөрөмд шилжүүлж тэндээс эргэлтийн усны цөөрөмд ус хуримтлагдана. Ингэснээр хаягдлын санд цөөрөм үүсгэх усны хэмжээг бууруулна. Жилийн ихэнх хугацаанд ус дахин ашиглах цөөрөмд орж баяжуулах үйлдвэрийн дэргэдэх усны цөөрөмд шилжиж орно. Хаягдлыг өөрийн урсгалаар нь сан хүртэл тээвэрлэж, дараа нь хаях цэгүүдэд насосоор шахна.


Хаягдлын сангийн байршил багтаамж

Хаягдлын аж ахуй нь баяжуулах үйлдвэрээс 0.2 км зайд оршино.

Хүснэгт 3. Хаягдлын сангийн байршил

Д/д	Уртгаг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	111	47	00.84	47	44	11.78
2	111	47	08.67	47	44	17.08
3	111	47	13.93	47	44	12.88
4	111	47	05.50	47	44	08.09

Баяжуулах үйлдвэрийн хаягдлын санг орон нутгаас өгсөн тусгай зөвшөөрөл бүхий талбайд, үйлдвэрээс баруун урагш байгуулахаар төлөвлөсөн ба үйлдвэрээс 0.2 км зайд 40.0 мян м² талбайтай, 200.0 мян м³ эзлэхүүнтэй байна.



Зураг 3. Хаягдлын сан

1.6. 2024 оны Баяжуулах үйлдвэрийн ашиглалтын ажлын төлөвлөгөө

Тус баяжуулах үйлдвэр нь 2024 онд 38.58 %-ийн CaF_2 –ын дундаж агуулгатай 50.0 мян.тн хүдэр флотацийн баяжуулалтаар 95.77%-ийн CaF_2 –ын агуулгатай ФФ-95 маркийн 21800 тн баяжмал гарган БНХАУ-ын Эрээн хотод борлуулахаар хийлээ.

2024 онд "Дожир" уурхайгаас 24.61 мян.тн хүдэр олборлоно. "Дожир" уурхайн талбай дээр 2023 оны үлдэгдэл 9.58 мян.тн хүдэр байгаа. "Ананд баян тал"ХХК, "Түшигт ээл"ХХК-с нийт 15.81 мян.тн хүдэр авахаар гэрээ хийсэн бөгөөд нийт 50 мянган тн хүдрийг баяжуулахаар төлөвлөсөн.



Зураг 4. Баяжуулах үйлдвэр

БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал:

Хэнтий аймгийн Баян-Овоор сум нь засаг захиргааны хувьд 4 багт хуваагддаг. Үүнд: Дэлгэрхаан (1-р баг), Наран (2-р баг), Сүмбэр (3-р баг), Жавхлант (4-р баг), уурхайн хамгийн ойр орших төв суурин газар нь Баян-Овоо сумын төв юм. Улаанбаатар хотыг зүүн аймгуудтай холбосон автомашины хатуу хучилттай замаас 25км-г байршдаг. Сумынхаа баруун талаар Батноров, хойд талаараа Норовлин, зүүн талаараа Дорнод аймгийн Хөлөнбуйр, урд талаараа Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түмэнцогт сумдын нутаг дэвсгэртэй хиллэдэг бөгөөд 338.1 мян.га нутаг дэвсгэрийг эзлэн оршдог. 2023 оны жилийн эцсийн байдлаар 2000 гаруй хүн амтай, 1052 өрхтэй, 295788 манган толгой малтай байна. Хүн амын үндсэн хэсэг нь халх үндэстэн. Амьжиргааны эх үүсвэр нь мал аж ахуй бөгөөд сум суурин газарт төрийн байгууллагад ажиллах болон худалдаа наймаа эрхлэн амьдарна. Малтай өрх сумын нийт өрхийн 88.8%-ийг эзэлж байна. Үүрэн телефоны бүх сүлжээнд холбогдсон.

1.2. Байгаль орчны төлөв байдал:

Төслийн талбайн газрын гадарга, физик газарзүй: Монгол орны газар зүйн мужлалаар тал хээрийн болон Хангайн бүсийн заагт орших учраас гадаргын хувьд намхавтар, нам дов толгодорхог болон нам уулын рельеф зонхилж байдаг. Гадарга нь тэгш оройтой, налуу, хажуутай жигд үргэлжилсэн маягийн толгодтой. Хүдрийн талбайн хувьд үнэмлэхүй өндөр нь далайн түвшинээс дээш 995-1010м байх бөгөөд гадаргын харьцангуй өндөр нь 10-20м байдаг.

Уур амьсгал: Ордын нутаг дэвсгэр нь бүхэлдээ эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд

хамаарна. Ажиглалтаас үзэхэд цаг уурын температур эрс хэлбэлздэг, хур тунадас багавтар, агаар чийгшилт харьцангуй бага хуурайвтар байдаг. Сарын хамгийн бага дундаж температур нь 1-р сард $-22-32^{\circ}\text{C}$, хамгийн өндөр дундаж температур нь 7-р сард $20^{\circ}+25^{\circ}\text{C}$ байдаг ба дулааны улирал 9-р сар дуустал үргэлжилдэг. Хур тунадас жилд дунджаар 160-180мм хүрнэ. Энд баруун хойноосоо чиглэлтэй салхи зонхилно. Салхины хурд 2.8-7.3м/сек хүртэл хурдасч шороон ба цасан шуурга шуурч хүчтэй салхилах болсон.

Геологийн тогтоц: Төслийн талбай нь Баянхонгорын структур-металлогенийн бүсийн Байдрагийн өргөгдөл, Хөх булаг алтны хүдэржилт, алтны шижирмэг хуримтлал бүхий талбайн хэмжээнд байрлана. Талбайн стратиграфийн ангиллыг 2011-2014 онд явуулсан УГЗ-200 төслийн хэмжээнд зохиогдсон 1:200000 болон Д.Андреас нарын 1966-1969 онд явуулсан 1:100000-ны геологийн зураглалын ажил гүйцэтгэж явуулсан. Хөх булагийн алт, зэсийн орд нь клино-пироксен-гранаттай скарны 11 биетээс бүрддэг. Эдгээр биетүүд нь ихэнхи нь боржиндиоритын массиваас 100-500 м зайд алслагдсан, зарим нь хиллэсэн хүдэржилт нь гантигжсан шохойн чулууны үелэл ан цавын дагуу 0.01-0.4 м үүр хэлбэрээр илэрдэг ба скарны биетүүд нь халькопирит, борнитийн шигтгээ, оюу, номингийн өнгөр, хааяа гадаргуугаас авсан цэгэн сорьцоос 1 мм хүртэл хэмжээтэй алтны мөхлөг агуулах бөгөөд алтны агуулгыг 0.1-10.6 г/тн гэж Д.Андреас тодорхойлсон. Харин 1995-1998 оны судалгаагаар скарны хүдэржилтээс авсан цэглэн сорьцны химийн шинжилгээгээр алтны агуулга 4.9-20.69 г/тн, 2.14-125.5 г/тн-ы мөнгөний агуулгыг тогтоосон байдаг.

Хөрс: Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй. Талбайн хэмжээнд хүрэн, цайвар хүрэн, бор хүрэн хөрс зонхилох ба голдуу элсэнцэр, шавранцар агуулна. Хужирлаг цайвар шаргал хөрс нь эх газрын нуурын гаралтай шавранцараас тогтоно. Хөрсний ялзмагт үеийн зузаан нь 0.15-0.2м хааяа 0.3- 0.4м хүртэл хэлбэлзэнэ. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хонхор хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл хажуу нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн. Ургамлын бүрхэвч бүрдүүлэгч гол нэр төрлийн өвс ургамал нь шивээ, хялгана, хазаар, агь, таана, хөмүүл, шарилж, божмог гэх мэт. Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хонхор хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл хажуу нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн байдаг.

Гидрогеологи, усан сүлжээ: Гадаргуугийн усан сүлжээний хувьд булаг, шанд, хуурай сайруудтай. Түр зуурын урсгал усны нөлөөгөөр үүссэн жалга сайрууд нь гүн биш ховил үүсгэх ба нэг их урт үргэлжилдэггүй. Хуурай сайрууд нь зун болон намрын улиралд усархаг бороо орсны дараа түр хугацааны урсгал устай байх бөгөөд цугларсан ус нь томоохон хөндийнүүдэд шалбааг тойром үүсгэнэ. Энэ нь багавтар хугацаанд тогтоод хур тунадас дахин орж тэжээгдэхгүй бол хатаж ширгэн алга болдог. Ордын орчимд талбайгаас 8км зайтай Хэрлэн гол урсах ба бороотой үед түр зуурын урсгалтай горхи хөндий амууд даган урсдаг.

Амьтан, ургамлын аймаг. Амьтан ургамлын аймаг болон уур амьсгалын хувьд говь, тал хээрийн аль алиных нь шинжийг агуулсан холимог байдалтай. Ургамлын аймаг харьцангуй сийрэг тачирхан ургасан өвстэй бөгөөд илчлэг, тэжээллэг чанартай байдаг. Энд таана, хөмүүл, ерхөг зэрэг ургамал ургах бөгөөд бороо хур элбэгтэй цаг агаарын тааламжтай нөхцөлтэй үед ургамал харьцангуй сайн өтгөн ургадаг.

Ан амьтны хувьд харьцангуй төрөл зүйлийн хувьд багавтар байдаг. Энд тарвага, зурам, оготно, цагаан зээр, үнэг, хярс, туулай, чоно байхаас гадна жигүүртэн шувуудаас сар, тас, элээ хааяа талын бүргэд байна. Жижиг хорхой шавьж харьцангуй элбэг.

Түүх, соёлын дурсгалт зүйлс: Төслийн талбай нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

“Хайлуур жонш баяжуулах үйлдвэр”-ийн төслийн байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг хийж, тайланг боловсруулахдаа төсөл хэрэгжих талбайн байгаль орчны өнөөгийн төлөв байдал, ашиглах технологи, ашиглалтын параметрууд, төслийн үйл ажиллагаанд хамаарах хууль эрх зүйн орчин, нийгэмд үзүүлэх эдийн засгийн үр өгөөж зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан, Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яамны Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал” байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг **магадлан жагсаах** (checklist) аргаар үнэлсэн.

Хүснэгт 4. Нөлөөллийн үнэлгээний систем

Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал
10 - Маш их	5 – Байнгын (30- дээш жил)	5 - Олон улсын хэмжээнд	5 - Гарцаагүй
8 – Их	4 - Урт хугацааны (15-30 жил)	4 - Үндэсний хэмжээнд	4 - Өндөр магадлалтай
6 - Дунд	3 - Дунд хугацааны (5-15 жил)	3 - Бүс нутгийн хэмжээнд	3 - Дунд магадлалтай
4 - Бага	2 - Богино хугацааны (0-5 жил)	2 - Орон нутгийн хэмжээнд	2 - Бага магадлалтай
2 - Маш бага	1 - Түр зуурын	1 - Тухайн орчны хэмжээнд	1 - Тохиолдохгүй
0 - Нөлөөлөлгүй			
Хамгийн өндөр оноо 25 болох бөгөөд түүнийг 100 % гэж үзвэл			
>75 %	Нөлөөллийн зэрэглэл өндөр		
40 %- 75 %	Нөлөөллийн зэрэглэл дунд		
<40 %	Нөлөөллийн зэрэглэл бага		

Нөлөөлөл тус бүрт эдгээр хүчин зүйлүүдийг эрэмбэлсний дараагаар үүсэх магадлал ба хор уршиг гэсэн 2 зүйлийн зэрэглэлийг дараах томъёог ашиглан тооцно:

$$\text{Оноо} = (\text{Эрчим} + \text{Үргэлжлэх хугацаа} + \text{Хамрах хүрээ}) \times \text{Магадлал}$$

Онооны зэрэглэлийн хамгийн их утга нь 100 %-тай тэнцүү байна. Байгаль орчны боломжит нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээтэй уялдуулан Их, Дунд, Бага гэж зэрэглэн ангилна.

Хүснэгт 5. Нөлөөллийг үнэлэх

Үнэлгээний хувь	Нөлөөллийн зэрэглэл	Тайлбар
>75 %	БО-нд үзүүлэх нөлөөлөл Их байгааг илтгэх	Энэ тохиолдолд ямар бууруулах арга хэмжээ байж болох вэ гэдгээс үл хамааран энэ нь төслийг эхлүүлэх эсэх талаар шийдвэр гаргахад нөлөөлнө.
30-75 %	БО-нд үзүүлэх нөлөөлөл Дунд зэрэг (М) байгааг илтгэх	Бууруулах арга хэмжээ төлөвлөхгүй л бол энэ нь төслийг эхлүүлэх шийдвэрт нөлөөлнө. Дунд зэрэглэлийн нөлөөлөл нь менежментийн төлөвлөгөө гаргахыг зайлшгүй шаарддаг. Хэрэв менежментийн төлөвлөгөө боловсруулахгүй бол төслийг эхлүүлэх эсэх талаарх шийдвэрт ч нөлөөлж болзошгүй.

<30 %	БО-нд үзүүлэх нөлөөллийн зэрэглэл Бага (L) байгааг илтгэх	Төслийг эхлүүлэх эсэх талаарх шийдвэрт нөлөө үзүүлэхгүй. Маш бага нөлөөлөл нь төслийн төлөвлөлт, дизайнд өөрчлөлт оруулахад хүргэдэггүй бөгөөд бууруулах арга хэмжээний өөр хувилбаруудыг ашиглах шаардлагагүй байдаг.
-	Нөлөөгүй	Нөлөөлөлгүй буюу байхгүй.

Хүснэгт 6. Төслөөс агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ

Агаар орчинд учруулах сөрөг нөлөө	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөллийн зэрэг
Шууд нөлөөлөл							
Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх, ачиж буулгах үйл ажиллагаануудаас тодорхой хугацаанд үүсэх тоосжилт	8	2	1	5	16	64	Дунд
Хүдэр жигдрүүлэлт хийх, хүдэр бутлах явцад агаарт үүсэх тоосжилтоос агаар бохирдох	6	2	1	4	13	52	Дунд
Хүдэр тээвэрлэлтийн үед замаас тоосжилт үүсэн агаар орчныг бохирдуулах, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх	8	2	1	4	15	60	Дунд
Хүдэр ачиж, буулгах үед үүсэх тоос, тоосонцор нь ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, орчныг бохирдуулах	4	2	1	2	9	36	Дунд
Хөрсний элэгдэл эвдрэл нь салхины нөлөөгөөр тоос босож, орчин тойрны агаар бохирдох, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	8	2	1	5	16	64	Дунд
Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс үүсэх угаар, болон халаалтын зуухны яндангаас нь агаар орчны хүний болон ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх	6	2	1	3	12	48	Дунд
Хог хаягдлыг зориулалтын цэгт хаяж, тухай бүрт зайлуулаагүйгээс орчны агаарт эвгүй үнэр тархах ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	6	2	1	3	12	48	Дунд
Шууд бус нөлөөлөл							
Ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх	6	1	1	3	11	44	Дунд
Ургамлын тоос хүртэлт, өсөлт хөгжилд нөлөөлөх улмаар бэлчээрийн доройтол бий болох	8	2	1	3	14	56	Дунд
Үр дүн (ерөнхий дундаж)						52.0	Дунд

Төслөөс гүний усанд учруулах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээнээс харахад нийт нөлөөллийн зэрэг нь дунд зэрэг буюу 60 хувь байна. Үүнд жонш баяжуулалт болон ахуйн хэрэглээнд ус ашиглах бөгөөд энэ хэмжээгээр гүний усны нөөцийг багасгах нөлөөлөл их, баяжуулалт,

хаягдлын сангаас ялгарах бохир ус болон унд ахуйн хэрэглээнээс гарах бохир ус хөрсөнд алдагдсанаар нэвчилт үүсэж гүний усыг бохирдуулах, тоног төхөөрөмж болон авто тээврийн хэрэгслээс шатах тослох материал алдагдсанаас хөрсөөр дамжин гүний ус бохирдох нөлөөллүүдийн зэрэг дунд богино хугацаанд эрчимтэй нөлөөлөл үүсгэхээр байна.

Хүснэгт 7. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөллийн шинж чанар
Агаар орчин			
1	Тоосжилт	-Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа -Хүдрийн овоолго үүсгэх -Хөрсний овоолго үүсгэх -Тээвэрлэлт -Далан -Ухаш олборлолт	-Улирлын чанартай -Хамрах хүрээ хязгаарлагдмал -Амархан сарнина.
2	Хийн хаягдал, утаа	-Автомашин -Уурхай болон үйлдвэрийн автотехникүүд	-Агаар бохирдуулагч хөдөлгөөнт эх үүсвэр -Хадгалагдах ба тархах хүрээ хязгаарлагдмал -Амархан сарнина.
Усан орчин			
3	Хатуу болон шингэн хог хаягдал	-Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал -Шатах тослох материалын хаягдал -Бохир ус болон үйлдвэрийн технологийн ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал	-ШТМ асгарснаас хөрс, хөрсний ус бохирдох -Хур борооны усаар аливаа хог хаягдал, асгаралт угаагдаж хөрс болон хөрсний ус бохирдуулах -Хөрсний шинж чанар өөрчлөгдөх, хөрс бохирдох, эвдрэх
4	Үйлдвэрийн үйл ажиллагаа	-Үйлдвэрийн баяжуулалтын үйл ажиллагаа	-Үйлдвэрлэлийн явцад хөрсний ус илэрч, карьер усанд автах -Газрын доорх усны нөөц багасах -Гадаргын ус болон хөрсний ус бохирдох
Хөрсөн бүрхэвч, геологийн тогтоц			
5	Хөрсний элэгдэл, эвдрэл	-Хөрс хуулалт -Барилга байгууламж барих -Автотехникийн үйл ажиллагаа	-Хамрах хүрээ хязгаарлагдмал -Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөх
6	Бохирдол	-Ахуйн хог хаягдал ил задгай асгах -Хаягдлын далан шүүрэх, химийн бодис алдагдах	-Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана. -Хамрах хүрээ хязгаарлагдмал -Хөрсний шинж чанар өөрчлөгдөх
Ургамлан нөмрөг			
7	Ургамлын талхагдал	-Авто зам -Ашиглалтын талбай -Барилга байгууламжуудын орчин -Тоосжилт	-Хэмжээ хязгаарлагдмал ба ургамалжуулалт хийснээр нөхөн сэргэх -Тухайн орчны ургамлан нөмрөгийн төрөл зүйл багасах, хомсдох
8	Ургамлан нөмрөг устах	-Нэн ховор, ховор ургамлыг таньж мэдэхгүй харьцах	-Төрөл зүйл өөрчлөгдөх -Устах
Ан амьтан			

9	Хордолт	-Хог хаягдал болон шатах гослох материалын хаягдал	-Хөрсөн дэх бичил биетэн, шавж устах
10	Дайжих	-Дуу чимээ -Уурхай болон үйлдвэрийн үйл ажиллагаа	-Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих
Нийгэм, эдийн засгийн орчин			
11	Үндсэн хөрөнгө	-Татварын орлого -Бүтээгдэхүүн -Үйлчилгээний худалдан авалт, орлого	-Төсөвт татвар төлөх -Ойролцоох оршин суугчид, аж ахуй эрхлэгчдийн орлого нэмэгдэх, амьжиргаа дээшлэх
12	Ажлын байр	-Ажлын байр шинээр бий болох	-Орон нутгийн иргэдээс ажилд авах

Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл:

- Төслийн үйл ажилагаанаас газрын гадарга ландшафт өөрчлөгдөх
- Төслийн үйл ажиллагаанаас өртсөн газрын хэвлийд нөлөөлөх, өөрчлөлтөд орох
- Хаягдал чулуулгийн овоолгоос газрын гадарга, агаар, усан орчинд бохирдол үүсэх
- Газрын хэвлийд үүсэх хоосон орон зайд мал амьтан унах аюултай нөхцөл байдал бий болох
- Газрын хэвлийд хоосон орон зай үүссэнээр ойр орчны газрын гадаргад хөрсний нуралт, цөмрөлт бий болох
- Гадаад дотоод тээврийн зам дагуух хөрс газрын гадаргад эвдрэл үүсэх
- Уурхайн барилга байгууламж, кемп, ажлын байрны талбайн газрын гадаргад өөрчлөлт үүсэх
- Газрын хөл ургамал ихсэж хөрс доройтож, цөлжих, талхлагдах
- Газрын хэвлий ландшафтад гарсан өөрчлөлттэй холбоотойгоор экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд өөрчлөлт орох, амьтдын амьдрах орчин хязгаарлагдах

Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:

Төслийг эхлүүлснээр агаар, орчны чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь дараах эх үүсвэрээс үүснэ. Үүнд:

- Үйлдвэрийн хүдэр жигдрүүлэх явцад
- Хүдэр бутлах үйл ажиллагааны ухаж ачих үед
- Бутлах үйл ажиллагааны үед
- Ногоон байгууламжын бүтээн байгуулалтын үед
- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн
- Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрээс гарах хийн хаягдал
- Хог хаягдлыг зориулалтын цэгт хаяж, тухай бүрт зайлуулаагүйгээс орчны агаарт муухай үнэр тархах
- Төслийн хүрээнд агаар орчныг бохирдуулах гол эх үүсвэр нь баяжуулах үйлдвэрийн хүдэр жигдрүүлэлт, бутлах үйл ажиллагааны ухаж ачих, буталж процесст, бүтээн байгуулалтын явцад тээврийн хэрэгслийн болон хүний хөдөлгөөнөөр газрын гадаргаас агаар дэгдэх тоос, тоосонцор, тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс үүсэх хийн хаягдал зэрэг байна.

Төслөөс усан орчинд нөлөөлөх нөлөөлөл:

- Уурхайд нийт 82 хүн, жилд нийт 166 хоног ажиллана. Төслийн ашиглалтын жилүүдэд нийт 142579.2 м³ ус хэрэглэх бөгөөд үүнээс унд ахуйд 1089.0 м³ ус, зам талбайн тоосжилт дарах усалгаанд 800.0 м³, уурхайн нөхөн сэргээлтэд нийт 860.0 м³ ус, технологийн усны хэрэгцээнд 139830.3 м³ ус ашиглагдахаар байна. /Ус хэрэглээний нормыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын дагуу баримтлах нормоор тооцов/.
- Жонш баяжуулалт болон ахуйн хэрэглээнд ус ашиглах бөгөөд энэ хэмжээгээр гүний усны нөөцийг багасгах
- Баяжуулалт, хаягдлын сангаас ялгарах бохир ус болон унд ахуйн хэрэглээнээс гарах бохир ус хөрсөнд алдагдсанаар нэвчилт үүсэж гүний усыг бохирдуулах
- Тоног төхөөрөмж болон авто тээврийн хэрэгслээс шатах тослох материал алдагдсанаас хөрсөөр дамжин гүний ус бохирдох
- Гүний худгийн ойр орчимд газар доорх усны ариун цэврийн хамгаалалтын бүсийн дүрэм журмыг баримталж ажиллаагүйгээс худаар дамжин гүний усыг бохирдуулах

Төслөөс хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр 3.4 га талбайн хөрсөн бүрхэвч хуулагдах, ухагдах, дарагдах хэлбэрээр эвдрэлд өртөнө.
- Төслийн шинээр бүтээн байгуулалт болох хаягдлын сангийн талбайн суурийн ажил явуулахдаа хөрстэй шууд байдлаар харьцах учраас хөрсөн бүрхэвч элэгдэл, эвдрэлд орно
- Төслийн үйл ажиллагааны улмаас ойр орчмын хөрс элэгдэл эвдрэлд өртөж үржил шимээ алдах
- Хөрсний морфологи тогтоц алдагдаж, үржил шимт нөөц нь багасах
- Төслийн ойр орчмын хөрс хийсэх, талхлагдах зэргээр шинж чанар нь өөрчлөгдөх
- Шатах, тослох материал ил задгай газарт асгарснаас хөрс бохирдох
- Орчны зам талбайн тохижилт муугаас үүдэн авто тээврийн хэрэгсэл, хүний хөлөөр хөрсөн бүрхэвч доройтох

Төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй үйлдвэрийн болон ахуйн хаягдлаас хөрс бохирдох

Төслөөс биологийн төрөл зүйл, түүний амьдрах орчинд үзүүлэх нөлөөлөл:

- Шинээр хаягдлын сан байгуулах хаягдлын сангийн талбайн хэмжээгээр ургамлан нөмрөг устах Төслийн үйл ажиллагаанаас авто машины хөдөлгөөний улмаас үүсэх тоосжилт
- Хатуу хог хаягдлыг тусгайлан бэлдсэн цэгт хаяхгүйн улмаас ургамлан нөмрөгийн үхжилтийг бий болгоно
- Төслийн талбайд авто тээврийн хэрэгсэл, хүний үйл ажиллагаанаас ургамал ургаж буй газруудыг талхагдалд оруулах
- Амьтдын идэш тэжээл эрж олох газар өөрчлөгдөх, хумигдах, идэш тэжээлийн хомсдол үүсэх
- Амьтдын орогнох нүх, үүр, үржлийн газар өртөх, амьтдын тоо толгой буурах
- Баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын үед дуу чимээ тоосжилт зэргээс үүдэн амьтад дайжих Төслийн үйл ажиллагааны үед ухсан нүх суваг шуудуу зэрэгт амьтад унаж бэртэх

Химийн бодисын ашиглалтаас үзүүлэх нөлөөлөл:

-Агаарын чанарт:

- Тээвэрлэлт, ашиглалт, хадгалалтын горим алдагдсанаас ууршиж, дэгдэмхий бодисууд агаарт тархах, дулааны үйлчлэл, гэрлийн нөлөөгөөр задрах, урвалд орох, үүссэн хорт нэгдлүүд нь салхиар тархах зэргээр орчны агаарын чанарын үзүүлэлтийг өөрчлөх
- Хаягдлыг шатаах аргаар устгах үед хортой хий ялгаран агаарын чанарт сөргөөр нөлөөлөх
- Болзошгүй осол, гал түймэр, тэсрэлт, байгалийн гамшгийн үед үүсэх хорт хийн дэгдэлт нь агаарын чанарт нөлөөлөх төдийгүй хур тунадсаар дамжин гүний ус, ургамал, хөрсийг бохирдуулж улмаар мал, амьтдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

-Гадаргын болон гүний усанд:

- Химийн бодисыг хадгалах агуулахын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдоос үүдэн гадаргын түр урсац, тогтоол усанд химийн бодис нэвтрэн орох, улмаар түүний урсацаар тархаж, голдирлын дагуух усыг бохирдуулах, гүний усанд нэвчиж болзошгүй.
- Тээвэрлэлт, түгээх, хүлээн авах үйл ажиллагааг технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг тогтоол ус, түр урсацын голдирлуудад асгах, түр зуурын үерт өртөж тухайн урсацын усыг бохирдуулах, бохирдлын эх үүсвэрийг бий болгох
- Агуулахын нормоос илүү болон ашиглалтгүй химийн бодис, материалын хуримтлал үүсэх нь хур бороо орох үед буй болсон гадаргын усыг бохирдуулах. Мөн тухайн цэгт химийн бодисоор бохирдсон усыг технологийн горим зөрчиж хөрс, түр зуурын урсацын голдиролд алдсанаас гадаргын болон газар доорх ус бохирдох

-Хөрс, ургамалд:

- Химийн бодисын хадгалалт, агуулахын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдоос химийн бодис хөрсөнд их хэмжээгээр алдагдах
- Тээвэрлэлт, түгээх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, хөрс хордох, улмаар гадаргын болон гүний ус, ургамал амьтанд дам нөлөө үзүүлж болзошгүй.
- Тээвэрлэх болон хаягдлыг устгах горим зөрчигдсөний улмаас химийн бодис хөрсөнд нэвчиж, ургамалд сөрөг нөлөө үзүүлэх
- Галын аюулын үед химийн бодисын шаталтаас үүссэн утаа, ууршиж, дэгдэмхий бодисуудын ууршилтаас үүссэн хортой хий хур тунадсаар дамжин ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

-Амьтны аймагт:

- Осол аваар, гал түймэр, гамшгийн үед хөрсөнд алдагдсан буюу агаарт дэгдсэн хортой хий, шатамхай бодисын хорт утаа хур тунадсаар дамжин ургамалжилтад нөлөөлж, өвс тэжээлээр дамжин мал амьтан хордох
- Химийн хортой бодис агуулсан усаар мал, амьтан ундаалснаас хордох
- Хортой бодисуудыг хамгаалалтгүй байлгаснаас мал амьтан идэх, амьсгалах зэрэг шууд замаар сөргөөр нөлөөлж болзошгүй.

-Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл:

- ✓ Төсөл хэрэгжих талбайн ойр орчинд айл, малын суурьшил байхгүй.
- ✓ Төслийн нөлөөллийн бүсэд төвлөрсөн суурин байхгүй.

- ✓ Технологийн үйл ажиллагаанд химийн бодис ашиглах тул хүний эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй.
- ✓ Уурхай болон үйлдвэрийн үйл ажиллагааны үед машин механизмын дуу чимээ, тоосжилтоос хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.

-Төслөөс нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл:

- Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн, шугам сүлжээний гэмтэл, гал, усны гэнэтийн аюул учирч болзошгүй.
- Төсөл хэрэгжих явцад ажлын байр нэмэгдсэнээр нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой хэмжээний эерэг нөлөөг үзүүлнэ.
- Орон нутгаас нийлүүлэх боломжтой хүнсний хангамж, ахуйн хангамж, түлш шатахуун нийлүүлэлт зэрэг материаллаг эрэлт үүснэ.
- Орон нутгийн төсөвт НӨАТ, ХАОАТ, АМНАТ, эрүүл мэнд, нийгмийн даатгал, үл хөдлөх хөрөнгийн татвар, өөрөө явагч хэрэгслийн татвар, газар, ус ашигласны төлбөр, хог хаягдлын хураамж зэрэг орлогууд төвлөрнө.

**БҮЛЭГ IV. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

"Ханшашир" ХХК-ийн 2024 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах арга хэмжээ буюу төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэхэд оршино. "Ханшашир" ХХК-ийн Дожир жоншны хүдрийг далд уурхайн аргаар олборлох уурхайн баяжуулах үйлдвэрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан БОМТөлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, 2014 оны А-117 тоот тушаалын 4-р хавсралтаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тус тус баримтлан боловсруулж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудсыг хөтөлбөрт хавсаргасан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний ажил хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, техникийн нөхөн сэргээлт, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, осол эрсдлийн менежмент, хог хаягдлын менежмент, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг төлөвлөгөөнүүд багтсан. 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд **20 000 000** сая.төг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримтлах арга зүй, стандарт, холбогдох эрх зүйн баримт бичгийн заалт, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, гүний усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,

- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичиг, стандартыг тодорхойлох
- Шаардлагатай хөрөнгө, зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох
- Дүйцүүлэн хамгааллаар гүйцэтгэх ажил, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд баяжуулах үйлдвэрийн орчинд ногоон байгууламж байгуулах ажлыг чанартай хийж гүйцэтгэх зэрэг орно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.

“Ханшашир” ХХК нь 2024 онд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд нийт **20 000 000** мян.төгрөгийг зарцуулахаар төлөвлөв. Энд тусгагдаагүй зардлууд нь ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон хөдөлмөр хамгааллын зардалд тусгагдсан болно.

Хүснэгт 8. Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын нэгтгэл

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Хөрөнгийн хэмжээ, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан, газрын хэвлий/	Мян төг	3 250 000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Мян төг	1 500 000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	9 355 000
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	0
5	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Мян төг	1 250 000
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Мян төг	500 000
7	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	Мян төг	4 145 000
8	Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын төлөвлөгөө	Мян төг	0
9	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	Мян төг	0
	Дүн		20 000 000

БҮЛЭГ V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ханшашир” ХХК-ийн “Дожир нэртэй хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах” төслийн Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад төслийн үйл ажиллагаанд технологийн шинэчлэлт болон удирдлага зохион байгуулалтын оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үүсэж болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлнэ. Мөн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартуудыг мөрдөж хэвшүүлж ажиллах нь үүсэх эрсдэл, сөрөг нөлөөллөөс хамгаалах гол үндэслэл болно.

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

Агаарын чанарт үзүүлэх хамгийн их утга 100-1000м зайд нөлөөлөл буурах зай алгуур, түүнээс цааш нөлөөлөл бага байна.

- Салхи багатай өдрийн цагийг үр бүтээлтэй ашиглах /ногоон байгууламж бий болгох/
- Зайлшгүй шаардлагатайгаас бусад газрын хөрс, ургамлыг эрүүл байлгах

- Жонш хадгалах буулгах талбайг тогтоож тогтоосон талбайг салхины зүг чигийг харгалзан байгуулах, тархахаас сэргийлэх арга хэмжээ авах,
- Бутлагчийг суурилуулахдаа хүдэр өгөх болон гаргах нүхийг битүү төмөр хаалтаар тусгаарлах,
- Хуурай материал ангилах зориулалттай шигшүүрийг тусгай тасалгаанд байрлуулан тоос сорогч байгууламжид холбон усаар тоос дарах арга хэмжээ авах,
- Байшин барилгын шигшүүр, байрлуулах талбай, бүтээцийг доргио хүлээн авч шингээн шигшүүрийн орчны ажлын байрны доргионы хэмжээ ариун цэврийн нормоор тогтоосноос дээшгүй байх нөхцөлийг хангахаар тооцоолон хийх,
- Шигшүүрийн доргионы явцад үүсэх шуугианыг шингээхийн тулд барилгын шал /хучилт/ шигшүүрийн тулгуурын хооронд резин жийргэвч пуржин амортизатор угсрах. Жийргэвчийн зузаан, амортизаторын талбайг тооцож тодорхойлох,
- Баяжуулах фабрикийн хүлээн авах бункерт хүдрийг хүлээн авах явцад тоос гаргахгүй байх, багасгахын тулд өөрөө буулгагч вагон, автомашин хүдэр асгах эгшинд залгагдан ус шүршдэг автомат шүршин чийглэх байгууламжийг бункерын аманд суурилуулан тавих шаардлагатай,
- Технологийн ажиллагааг боловсронгуй болгон, тоос үүсгэдэг тоног төхөөрөмжүүдийг битүү болгох, далдлах
- Үйлдвэрийн байр тасалгааг хэсгийн болон ерөнхий агааржуулалтын байгууламжаар хангах
- Усыг жижиг дусал болгон шүрших зорилгоор тусгай шүрших тоноглол-форсунк хэрэглэх,
- Цахилгаан техник хэрэгсэл, авто тээврийн хэрэгслийг сонгохдоо шатахуун зарцуулалт бага, ашигт үйлийн коэффициент өндөр технологи сонгох шаардлагатай бөгөөд орчин үеийн дэвшилтэт технологиуд нь дуу шуугианы нөлөө бага байдаг.
- Төслийн үйл ажиллагаанд ашиглах том оврын болон бусад авто тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд тээврийн хэрэгслүүдэд тогтмол засвар үйлчилгээг хийж, чанар сайтай шатах тослох материал ашиглах, утааны шүүлтүүр хэрэглэх, яндангаас гарч буй утааны хяналтын хэмжилтийг тогтмол хийлгэх, ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгслийг ашиглахгүй байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай,
- Төслийн барилга байгууламжийн зураг төсөлд тусгагдсан газруудыг технологийн дагуу хучилт хийж байгуулах, тэмдэгжүүлэх,
- Ахуйн хог хаягдлыг ариун цэврийн бүсийн гадна, түүнээс 60 м-ээс багагүй зайд, салхины зонхилох чиглэлийн дагуу, төслийн барилга байгууламжийн доод талд ус үл нэвтрэх дотортой, зориулалтын саванд цуглуулах
- Төслийн хүрээнд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийг галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох,
- Орчны болон ажлын байрны дуу чимээний хэмжээг тогтоож шаардлагатай тохиолдолд хамгаалах хэрэгсэл ашиглах

Усны нөөц горимд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- Хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн ойр орчмын уст цэгүүдэд фторт ион тархах болзошгүй учир тогтсон хугацаанд мониторинг судалгаа хийж, усны химийн шинжилгээг хийлгэж байх шаардлагатай,
- Үйлдвэрийн ус ашиглалтаас үүдэн газрын доорх усны нөөц, чанарт нөлөөлөх нөлөөллийг мониторингийн цэгүүд байгуулах шаардлагатай,
- Технологийн цэвэр ус хуримтлуулах байгууламжийн усны түвшинг байнга хэмжин хянаж байх,
- Ундны усны чанарын УСТ900-92 стандарт, гадаргын болон газар доорх усны ариун цэврийн хамгаалалтын бүсийн дүрэм, журмыг баримтлан ажиллах,
- Үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэгцээнд гүний худаг ашиглах бөгөөд тухайн худагт баталгаажсан тоолуур байршуулж хэрэглээгээ бүртгэлжүүлж тоолуурын заалтын дагуу усны төлбөрийг төлөх
- Гүний худаг орчимд Усны хуульд заасны дагуу энгийн хамгаалалтын бүс болон онцгой хамгаалалтын бүс 50м-ээр тогтоож, байнгын харуул хамгаалалттай байлгах, Шаардлагатай тохиолдолд камержуулж болно,

- Гадаргын болон газар доорх усны шинжилгээг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу хийлгэж байх,
- Шингэн хаягдлыг гүний усанд нөлөөлөхөөс урьдчилан сэргийлж бетонон доторлогоотой, тунаах дамжлага бүхий сиптек танканд байршуулж тодорхой хугацаанд задлагч, ариутгагч бодисуудыг хэрэглэх
- Ус ашиглалт ба хамгаалалт. Нэр томьёо ба тодорхойлолт MNS0017-1-1-10:1979-ын дагуу буюу ариун цэврийн байгууламж, бие засах газар болон хог хаягдлын цэгийг гүний хурдгаас 300-500 м зайд байрлуулах

Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- “Хайлуур жонш баяжуулах үйлдвэр”-ийн төслийн газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад Монгол улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй стандартуудын дагуу хөрс хуулах, хадгалах, хамгаалах, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг БОНБНҮ-ний нөхөн сэргээлтийн бүлэг, төлөвлөгөөнд тусгаснаар хийх шаардлагатай.
- Газрын хэвлийг ашиглуулахаар олгох журмыг чанд сахин биелүүлэх,
- Ашигт малтмалын нөөцийг ашиглахад үүсч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс газрын хэвлийг хамгаалах,
- MNS 5916:2008 стандартын 7.2-т зааснаар шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, хужиртах, хатуу биет чулуу, барилгын болон бусад хаягдалд дарагдаж бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх,
- Газрын хэвлийн тухай хууль болон газар эзэмших, ашиглах эрхийн журамд зааснаар уурхай, үйлдвэрийн талбайн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг уурхайн дарга, компанийн ерөнхий захирлаар батлуулан дотооддоо мөрдүүлэн ажиллах,
- Төслийн тээврийн хэрэгслүүдийг нэгдсэн тусгай нэг цэгт байрлуулах, талбайг тэмдэгжүүлэх,
- Төслийн талбайн доторх тээврийн хэрэгслийн явах хэсгийн эвдрэлийг нөлөөлөл багатайгаар шийдэхийн тулд тээврийн хэрэгслийн зорчих маршрутыг гаргах, хэрэгжилтийг уурхайн дарга хариуцан, зөрчсөн ажилтныг уурхайн дотоод журмаар хариуцлага тооцдог байх,
- Төслийн ашиглалтын талбайг төлөвлөгөөнд тусгагдсанаас үл хэтрүүлэх,
- Төслөөс газрын хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах хамгийн, нөлөөлөлд өртсөн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж, анхны байгалийн төрхтэй нь адил хэмжээнд хамгийн боломжит байдлаар дөхүүлэх,
- Уурхайн олборлолтыг мэргэжлийн байгууллагын батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу ашиглалтыг явуулах,
- Газрын хэвлийг ашиглаж байгаа Ханшашир ХХК нь өөрийн компанийн газрын хэвлийн ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний биелэлтийг хангах төлөвлөгөөг гаргаж, уулын ИТА, болон нийт ажиллагсдад уг дүрэм, хэм хэмжээний биелэлтэд хяналт тавих ажлыг тодорхой ажилтанд тухайлан хариуцуулсан байвал зохино. Ингэхдээ аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг бүх ажилчин, албан хаагчдаар судлуулж мөрдүүлэх, аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх, ажиллагчдын амь насанд аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, тэднийг аюулгүй газарт гаргаж, уг нөхцөл байдлыг арилгаж хэвийн болгох шаардлагатай арга хэмжээг шуурхай авах, аюулгүй ажиллагааны болон ариун цэврийн дүрэм, хэм хэмжээний шаардлагад тохирсон машин техник, тоног төхөөрөмж, материал, ажлын тусгай хувцас, бие хамгаалах бусад хэрэгслээр хангаж ажилчдад хэрэглүүлж хэвшүүлэх,
- Ашигт малтмалын нөөцийг ашиглахад үүсч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс газрын хэвлийг хамгаалах, ашигт малтмалын ордыг усанд автах, үер, гал түймрээс болон ашигт малтмалын чанар, ордын үйлдвэрийн үнэт чанарыг бууруулах буюу түүний ашиглалтыг хүндрүүлж болох бусад хүчин зүйлээс сэргийлэн хамгаалах; ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барих, уг талбайг ашиглах талаар тогтоосон журмыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зэргээр газрын хэвлийг хамгаалах талаар тавих үндсэн шаардлагыг хэрэгжүүлж ажиллах,
- Барилга байгууламжийг барихдаа шимт хөрсний үе давхаргыг хуулж, түүнийг нөхөн сэргээлтэд ашиглагдахаар тусгайлан овоолго хийж, элэгдэл өгөршлөөс хамгаалан чийглэх, ургамалжуулах зэргээр хадгалж хамгаалах,

- Ногоон байгууламжийг бий болгох,
- Төслийн ерөнхий төлөвлөлтийг зураг төслийн дагуу гүйцэтгэх, ойр орчмын зам, талбайг тохижуулах (авто тээврийн хэрэгслийн зогсоол, явган хүний зам)
- Түүхий эдийн агуулах, үйлдвэрлэлийн процесс, тээвэрлэлт зэргээс үүсэх тоосжилтийн хэмжээг бууруулснаар хөрсний үржил шим муудахаас сэргийлэх,
- Баяжуулах явцад үүсэх баяжуулалтын хаягдлын овоолгыг төлөвлөлтийн дагуу тогтворжуулж, хэлбэржүүлэлтийн ажлыг хийн төлөвлөсөн талбайгаас бусад газрын хөрсийг бохирдуулахаас сэргийлэх,
- Машин техникийн зогсоолын бохирдсон хөрсийг цэвэрлэж, бохирдсон хөрсийг хуулан авч тусгай нэвтрэхгүй материалаар доторлосон нүхэнд хийж саармагжуулах,
- Шатахуун, тослох материалаар хөрс бохирдуулахаас сэргийлэхийн тулд тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд анхаарч, шинэчилж, засвар үйлчилгээний ажил хийж байх,
- Төслийн талбайд болон ойр орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байх /хатуу, шингэн хог хаягдлыг тухай бүрд нь цэвэрлэж зөвшөөрөгдсөн газарт хаях, ариутгах ажлыг хийж байх/
- Хөрсний сорьц авч мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэх,
- Төслийн үйл ажиллагаанд аль болох бага хэмжээний хөрс өртөхөөр тооцож ажиллах,
- Үйлдвэрийн технологийн гадаад болон дотоод тээвэрлэлт, үйлчилгээний зориулалтын тээврийн хэрэгслийн зорчих сайжруулсан зам талбайг иж бүрэн тэмдэгжүүлэх, тээврийн хэрэгслүүдийг заасан маршрутын дагуу явуулж хяналт тавих,
- Үйлдвэрийн болон оффиссын ажилчдын зорчих явган зам, талбайг зориулалтын дагуу хатуу хучилттай болгож, тэмдэгжүүлэх
- Автомашины зогсоолын талбайг тэгшлэн шатах, тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж тэмдэгжүүлэх /төсөл хэрэгжих орчны зогсоол, машин техникийн шатах тослох материал асгарвал тухай бүрд нь элс, даавуу зэрэгт шингээн авч галын аюулгүй нөхцөлд /төмөр сав зэрэгт хийн шатааж/ ариутгах,
- Ажилчдын зүгээс ил задгай хог хаягдал хаях, хөрсийг бохирдуулахгүй байх талаар анхааруулга, сануулга өгөх,
- Ахуйн хатуу хог хаягдлыг тусгайлан бэлтгэсэн далан, хашаа хаалт бүхий тогтсон цэгт цуглуулах бөгөөд орон нутгийн захиргаатай хог хаягдлын гэрээ байгуулж, зохих төлбөрийг төлж ажиллах шаардлагатай. Шингэн хаягдлыг бетонон доторлогоотой, тунаах дамжлага бүхий сиптек танканд байршуулж тодорхой хугацаанд задлагч, ариутгагч бодисуудыг хэрэглэнэ.
- Үйлдвэрийн барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажлыг бүрэн гүйцэтгэж дууссаны дараа барилгын ажлын явцад элэгдэл, эвдрэлд орсон талбайг хэлбэршүүлж, ургамалжуулах,
- Эвдэрсэн газар, хөрсийг MNS 5917:2008 стандартын дагуу нөхөн сэргээх

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө эвдэгдэх, хөндөгдөх хөрсийг уулархаг хэсэгт өнгөн хэсгийн 40-50 см, хөндийн хэсэгт 80-95 см зузаантай ялзмагт давхаргыг тусд нь авч хадгалах, биологийн нөхөн сэргээлтэд ашиглах, мониторинг хийх,
- Хөрсөөр дамжин ургамлыг бохирдуулж болзошгүй хог хаягдлыг ангилж ялгах, хөрсөнд алдагдахааргүй хадгалах,
- Хог хаягдлын цэгийг тохижуулах (цемент, төмөр гадаргатай байх), орчиндоо тараахгүй байх талаар арга хэмжээ авах (хашаа хаалт барих) гэх мэт арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Хог хаягдлыг ангилал, шинж чанараас нь хамааран (Шингэн хог хаягдлыг тухай бүрд нь цэвэрлэж зөвшөөрөгдсөн газарт хаях, булаах, ариутгах ажлыг тогтмол хийж, гадны нөлөөллөөс тусад нь байлгах, амьтан, ургамал нөлөөлөхөөргүй нөхцөлд байршуулах), (Хатуу хог хаягдлыг хадгалах цэг байгуулан түүнд төвлөрүүлэн хаяж байх, Хатуу хог хаягдлын цэг нь зориулалтын тагтай байх, салхи шуургатай үед хог хаягдал хийсч орчноо бохирдуулахгүй байх ёстой),
- Зам талбайгаар зорчихдоо технологийн зам ашиглах. Тухайлбал: Зам тэмдэг тэмдэглэгээг сайтар байрлуулах, зам ашиглалтад уурхайн зүгээс хатуу хяналт тавих бодлогыг баримтлах нь ургамлан бүрхэвч устах, хөрс эвдрэх эрсдэлээс сэргийлнэ.

- Үйлдвэр орчмын зогсоол, замд машин техникийн шатах тослох материал асгарвал тухай бүрд нь элс, даавуу зэрэгт шингээн авч галын аюулгүй нөхцөлд /төмөр сав зэрэгт хийн шатааж/ ариутгах. Хатуу, шингэн хог хаягдлыг тухай бүрд нь цэвэрлэж зөвшөөрөгдсөн газарт хаях, булах, ариутгах ажлыг хийж байх.
- Төслийн эдэлбэр газраас бусад талбайн ургамлыг хамгаалахын тулд тогтсон нэг маршрутын дагуу явах, хамгаалалтын зурвас байгуулах
- Хуурайшилт ихтэй өдрүүдэд тоосжилт ихээр үүсэхээс хамгаалан зам талбайг услах, тоосжилтоос сэргийлэх
- Ойр орчиндоо ургах ургамал, ургамлын ургалтад хяналт тавьж, бүртгэх, ажиглалт явуулах
- Машин механизм, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол, засвар үйлчилгээний зориулалтын талбай гарган орчны ургамлыг талхлагдахаас сэргийлэх, хэрэгжилтийг уурхайн дарга хариуцан ажиллах, төлөвлөсөн талбайгаас бусад газарт олон салаа зам үүсгэн хөрс эвдрэл оруулах, ургамлыг талхагдуулсан тохиолдолд уурхайн дотоод журмын дагуу хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх
- Машин техникийн шатах тослох материал ойр орчинд асгарвал тухай бүрд нь элс, даавуу зэрэгт шингээн авч галын аюулгүй нөхцөлд /төмөр сав зэрэгт хийн шатааж/ ариутгах. Хатуу, шингэн хог хаягдлыг тухай бүрд нь цэвэрлэж зөвшөөрөгдсөн газарт хаях, булах, ариутгах ажлыг хийж байх, машин техникийн бүрэн бүтэн байдлыг тодорхой цаг хугацаанд шалгах,
- Аливаа газар хөндөлт бүрийн өмнө тухайн талбайн ургамлан нөмрөгийн суурь мэдээллийг цуглуулж, нөхөн сэргээлтийн ажилд тухайн нутгийн ургамлын үрнүүдийг ашиглаж, байгалийн бүлгэмдлүүдийг дахин сэргээх арга хэмжээ авч байх.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- Тухайн бүс нутгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, байгаль хамгаалагч, иргэдтэй санал солилцох, амьтдын төрөл зүйлийг хамгаалах арга хэмжээ зохион байгуулах,
- Төслийн үйл ажиллагааны үед үүсэх дуу чимээг аль болох бага түвшинд байлгах,
- Тээвэрлэлтийн зам дагуу ан амьтан, мал олноор бэлчээрлэх, нүүдэллэн явах зурвас газруудад тэмдэг тэмдэглэгээ хийх,
- Төслийн үйл ажиллагааны үед ухсан нүх, суваг шуудууг тухай бүрт битүүлж амьтад унаж бэртэх улмаар үхэж үрэгдэхээс сэргийлэх,
- Ажилчдад ан амьтдыг үргээх, агнахыг хориглох, сургалт сурталчилгаа хийх,
- Амьтдын идэш тэжээл эрж хайх, нүүдэллэх зам харгуй, нүх оромжийг анхааруулсан тэмдэгүүд байрлуулах, эрүүл хөрс газраар тээврийн хэрэгсэл хүнд машин механизмаар явахыг хориглох;
- Төслийн талбайн ойр орчмын ан амьтдын тоо толгойн өөрчлөлтийг хянаж, ажиглалт явуулж байх. Ингэснээр төслийн талбай болон түний ойр орчмын амьтдыг таньж мэдэх, тэдгээрийг хамгаалах арга хэмжээ авахад дөхөмтэй байх бөгөөд өвөлжилт хүндэрсэн үед малчдад өвс тэжээлийн тусламж үзүүлэх, зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэрэг орчны ан амьтдыг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Нүүлгэн шилжүүлэх, нутгийн иргэдэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

- Хаягдлын даланд хаалт хашлага хийж мал амьтанд унаж үрэгдэхээс сэргийлэх
- Өвөлжилт хүндэрсэн үед нутгийн иргэдэд өвс, хадлангийн тусламж үзүүлэх зэргээр орон нутгийн иргэдэд боломжит тусламж үйлчилгээг үзүүлэх
- Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж хэрэгжүүлж ажиллах
- Авто тээврийн хэрэгсэл зайлшгүй явах замын ойролцоо хэсэгт анхааруулах тэмдэг хадсан байх,
- Орон нутгийн иргэдэд уурхайн үйл ажиллагаатай холбогдолтойгоор үүсэж болзошгүй сөрөг нөлөөллүүд хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүрт мэдээлэл өгч байх
- Орон нутгийн иргэдийн амжиргааг дэмжин ажиллах /Сүү, мах зэрэг хоол хүнсний зүйлсийг орон нутгийн иргэд малчдаас авах/

- Иргэдийн ундны усанд сөрөг нөлөөлөл учрахаас сэргийлэн уурхайн ойролцоох унд ахуйн хэрэглээнд ашиглагддаг гүний худгуудаас дээж авч шинжилгээ хийлгэж байх,

Түүх, соёлын дурсгалт зүйлт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж:

- Төслийн талбайд өрөмдлөг хийх, хөрс хуулах ашиглалтын бусад үйл ажиллагаа явуулах тохиолдолд илэрсэн дурсгалуудыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, дурсгалуудыг малтан судлуулж талбайг чөлөөлүүлэх, түүх соёлын дурсгалт газруудад ажиглалт мониторинг хийх, газар хөндөх ажилд авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулах,
- Соёлын өвийг хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, үүнд ИТА, уурхайн дарга хяналт тавин ажиллах,
- Түүх, соёлын дурсгалд зар сурталчилгааны самбар, бичиг хадах, анхны хэлбэр төрх, хийц, бүтцийг өөрчлөхийг хориглох, ажилчид албан хаагчдад энэ талаар мэдээлэл өгөх
- Төслийн хэрэгжилтийн явцад ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олоход үед холбогдох хууль тогтоомж буюу МУ-ын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Баян-овоо сумын засаг захиргааны байгууллага, ШУА-ийн Түүхийн хүрээлэнд /ШУА-Түүх, археологийн хүрээлэн Утас:11458305/ даруй мэдэгдэх, хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор гүйцэтгэх шаардлагатай.

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж

- Байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ БОНБНУ-ний тайлан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын талаар уурхайн бүхий л түвшний инженер албан хаагчдад жил бүр уурхай эхлэхээс өмнө болон тодорхой хугацаагаар (сард нэг удаа) байгаль орчны мэргэжилтэн, байцаагчдыг оролцуулсан сургалт семинар зохион байгуулж байх
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлэх,
- Төсөл хэрэгжүүлэгч нь захирлын тушаалаар Байгаль орчны мэргэжилтэн, ХАБЭА-н ажилтан томилсон байх,
- Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах,
- Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай /Харьяалагдаж буй сум/ хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах,
- ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу уурхайн тоног төхөөрөмж, ажиллах хүн хүчний нөөцөд тулгуурлан тодорхой хуваарийн дагуу явуулах,
- Тус уурхайд осол аваар гарах гол хүчин зүйлс нь уурхайн хүнд оврын машин техник хэрэгсэл бөгөөд эдгээрийн ажиллуулах оператор, инженер техникийн ажилтнууд мэргэжлийн түвшинд мэргэшсэн байх,
- Ажлын байрны аюултай хортой хүчин зүйлийн нөлөөллийг арилгах, бууруулах, сайжруулахад шаардагдах мөнгөн хөрөнгийг компанийн санхүүгийн төсөв тооцоонд тусган оруулж төлөвлөх,
- Орон нутгийн удирдлага болон иргэдэд төслийн үйл ажиллагааны биелэлт, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаар танилцуулга, хэлэлцүүлгийг тогтмол хийж байх,
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайн гүйцэтгэлтэй ажиллахын зэрэгцээ хаалтын жилүүдэд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох хууль журам, стандартын дагуу хийж орон нутгийн байгууллагад хүлээлгэн өгөх,
- Байгаль орчны аудит, газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажлыг хоёр жил тутамд хийлгэх,
- Жил бүр ажлын төлөвлөгөөндөө орчны хяналт шинжилгээний зардлыг тусган хэрэгжүүлж байх,

- Тухайн аж ахуйн нэгж нь шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, тордолтын ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх,
- Агаарын чийг ба дулаан хэмжигч багаж байршуулах

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
<i>АГААРЫН ЧАНАР</i>								
Үйлдвэрлэл, төслийн үйл ажиллагааны үед ашиглах тээврийн хэрэгсэл зэргээс агаар орчинд тоосжилт үүсэх	1. Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хязгаарлах, тодорхой маршрутаар явуулж, жолооч нарт зөвөлгөө өгч ажиллах	Агаарын чанарын нөлөөллийн бүс	-	ҮАЗ-д	-	-	Дотоод, гадаад тээвэрлэлт хийх замын турш	-Агаарын болон агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4990:2010 Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага -Бензин хөдөлгүүртэй автомашин MNS 5013:2009 -Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
	2. Үйлдвэрийн дотоод замын арчилгаа тордлогоо хийж засаж сайжруулах, хурдны хязгаарлалтын тэмдэг тэмдэглэгээг засварлах	Агаарын чанарын нөлөөллийн бүс	ш	110000	2	220000	7 сард 1 удаа	
	3. Хуурайшилттай үед уурхайн зам талбай болон бусад тоосжилт үүсч болзошгүй гадаргууг услах	Агаарын чанарын нөлөөллийн бүс	м ²	ҮАЗ-д	18000м ₂	-	Хавар, намрын хуурашилт ихтэй үед 2 оос доошгүй удаа	
	4. Хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг зориулалтын газарт хугацаанд нь хийж, орчноо бохирдуулахаас урьдчилан сэргийлэх	Агаарын чанарын нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	2	-	7, 10 сард	
	5. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох агаарын бохирдлын төлбөр төлөх	Агаарын чанарын нөлөөллийн бүс	ш	ҮАЗ-д	1	-	Нэхэмжлэл үүссэн үед	

	6.Ажилчдыг тоосноос хамгаалах нэг бүрийн хэрэгслээр хангах	Агаарын чанарын нөлөөллийн бүс	ш	3000	200	600000	Норм, нормативаар
	7.Агаар бохирдуулах эх үүсвэрийн тооллого хийх	Агаарын чанарын нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	1	-	7 сард
	8.Ажилчдын амралтын өрөө, тасалгаануудад тогтмол чийгтэй цэвэрлэгээ хийлгэж, тоос үүсэхээс урьдчилан сэргийлэх	Агаарын чанарын нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	Өдөр тутам	-	Баяжуулах үйлдвэр ажиллах үед
	9.Баяжуулах үйлдвэрийн агааржуулалтын системийн ажиллагааг хянаж, засвар үйлчилгээг тогтмол хийлгэж хэвийн ажиллагааг хангах	Агаарын чанарын нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	2	7, 9 сард	Баяжуулах үйлдвэр ажиллах үед
Төслийн хог хаягдлын цэгээс ялгарах үнэр, тоос шороо, утааны бохирдол нь агаар орчинд сөрөг нөлөөлөх	1.Төслийн талбайд байгуулагдах хог хаягдал хадгалах түр цэгт стандартын дагуу ариутгал халдваргүйтгэлийг Мэргэжлийн байгууллагаар хийлгэх /үнэр ялгарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах/	Нөлөөллийн бүс	удаа	150 000	2	300 000	7, 9 сард 1 удаа
	2.Хог хаягдал хадгалах цэгийг хаягжуулах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Нөлөөллийн бүс	удаа	110 000	3	330 000	7 сард 1 удаа
	3.Ахуйн бохир ус хадгалах цэгт ариутгал халдваргүйтгэлийг Мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	2	-	Сард 1 удаа

	4.Химийн бодисын сав баглаа, боодлыг зориулалтын газарт хадгалах /асгарч, хаягдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах/	Нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	-	-	Сав баглаа боодлын хаягдал гарах бүрт	
Нийт мян.төг						1 450 000		
<i>ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ</i>								
Унд ахуй болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг их хэмжээгээр ашиглан усан орчинд сөрөг нөлөө үзүүлэх	1.Баяжуулах үйлдвэрт усыг дахин ашиглахдаа технологийн горимыг алдагдуулахгүйгээр ашиглах, ус ашиглалтад хяналт тавих	Усны нөөц горимд үзүүлэх нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	3	-	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэх үед	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль -Усны тухай хууль -ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт /Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай/ -MNS 13.060 50 Усны чанарын стандарт -Хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт хийх журам
	2.Усны тоолуурын бүрэн бүтэн байдал болон ашиглалтад хяналт тавьж, ус ашиглалтын мэдээг үйл ажиллагаа эхэлснээс тухай бүр холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлэн, төлбөрийг төвлөрүүлэх	Усны нөөц горимд үзүүлэх нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	3	-	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэх үед	
	3.Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах, эрүүл ахуйн бүсийн мэдээлэл бүхий самбар байршуулах, байнгын харуул хамгаалалттай байлгах	Усны нөөц горимд үзүүлэх нөлөөллийн бүс	удаа	110000	1	110000	8 сард 1 удаа	
	4.Ус ашиглалтын дүгнэлт гаргуулан, ус ашиглуулах гэрээг холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, ус ашиглалтын тайланг хүргүүлж, гэрээ дүгнүүлэх	Усны нөөц горимд үзүүлэх нөлөөллийн бүс	удаа	620000	1	620000	6 сард 1 удаа	
Нийт мян.төг						730 000		
<i>ГАЗРЫН ХЭВЛИЙ, ХӨРСӨН БҮРХЭВЧ</i>								
Үйлдвэрийн болон ахуйн	1.Захиргаа болон ажилчдын амрах байрны явган зорчих хэсгийн зам	Нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	1	-	8 сард 1 удаа	

хэрэглээнээс гарах хатуу шингэн хаягдлын улмаас хөрс бохирдох, эвдрэлд орох	талбайг зориулалтын хайрган хучилттай болгох							-Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль •Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS 5915:2008, •Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах техникийн шаардлага MNS 5916:2008, -Ашигт малтмалын тухай хууль -Газрын тухай хууль -Газрын хэвлийн тухай хууль
	2. Ахуйн хэрэглээнээс гарч буй бохирын хаягдлыг зориулалтын тагтай саванд хаях	Нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	-	-	Хаягдал гарах бүрт	
	3.Хөрсөнд болон бохирын цэгт ариутгал халдваргүйтгэл хийлгэх	Нөлөөллийн бүс	удаа	150000	2	300000	7, 8 сард	
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнө өр хөрс эвдрэл, бохирдолд орох	1.Баяжуулах үйлдвэрээс шинээр байгуулсан хаягдлын сан руу хаягдал зөөвөрлөх замыг засаж, тэмдэгжүүлэх	Нөлөөллийн бүс	ш	110000	2	220000	8 сард 1 удаа	
	2.Баяжуулах үйлдвэрийн техник, тоног төхөөрөмж болон авто тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний талбайг тос, тосолгооны материал асгарч хөрсөнд нэвчихээс сэргийлэн шалыг цементлэх	Нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	1	-	8 сард 1 удаа	
	3.Хаягдлын далангийн бүрэн бүтэн байдлыг хянаж, тухай бүрт нь засварлаж байх	Нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	1	-	Сард 1 удаа	
Үйл ажиллагаанаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох	1.Баяжуулах үйлдвэр болон хаягдлын сангийн байгууламжийн газрыг хууль тогтоомжийн дагуу ашиглах	Нөлөөллийн бүс	-	ҮАЗ-д	-	-	Үйл ажиллагааны турш	
	Нийт дүн					520000		

УРГАМЛАН НӨМРӨГ

Ургамлан нөмрөг доройтсоно ор идэш тэжээлийн хомсдол үүсэх	1.Олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Үйлдвэр орчмын нөлөөллийн бүс	удаа	110000	2	220000	8 сард 1 удаа	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль -Ургамал хамгааллын тухай хууль
	2.Баяжуулах үйлдвэрийн талбайд болон ажилчдын кемп орчмын боломжит хэсэгт ногоон байгууламж бий болгох, тохижилтын ажил хийх	Үйлдвэр орчмын нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	2	-	7, 9 сард 1 удаа	
	3.Баяжуулах үйлдвэрийн хүдэр тээвэрлэлтийн зам талбайг услах, хаягдлын далангаас тоосжилт үүсэхээс сэргийлж дагтаршуулж байх	Үйлдвэр орчмын нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	Тухай бүр	-	Эрсдэл үүсэх тохиолдол бүрт	
	Нийт дүн:					220000		
АМЬТНЫ АЙМАГ								
Төслийн үйл ажиллагааны үед амьтдын үүр, идэш тэжээлд сөрөг нөлөө үзүүлэх	1.Амьтдын идэш тэжээл эрж хайх, зам харгуй, нүх оромжийг анхааруулсан тэмдэгүүд байршуулах	Үйлдвэр орчмын нөлөөллийн бүс	удаа	110000	1	110000	9 сард 1 удаа	-Амьтны тухай хууль
	2.Мал, амьтдын нүүдлийн гарц гаргаж, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Үйлдвэр орчмын нөлөөллийн бүс	удаа	110000	2	220000	8 сард 1 удаа	
	3.Тэжээвэр амьтад орохоос сэргийлэн хашаа хаалт хийж бүрэн бүтэн байдлыг хянаж ажиллах, сэргээн засварлах арга хэмжээ авах	Үйлдвэр орчмын нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	-	-	Эвдрэл үүссэн үед	
Нийт дүн						330 000		
НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ /ТӨГ/							3,250, 000.00	

БҮЛЭГ VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Байгаль орчин, геологи уул уурхайн хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад хууль, тогтоомж, зааврын дагуу уурхайн үйл

ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага Монгол улсын стандартын дагуу зайлшгүй хийсэн байх үүрэгтэй. 2024 оны Баяжуулах үйлдвэрийн ашиглалтын төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй.

Хүснэгт 10. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
2	Биологийн нөхөн сэргээлт “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд	Баяжуулах үйлдвэрийн ногоон байгууламжийн талбайд нөхөн тарилт хийх	ш га	500 0.15	3000	1 500 000	9 сард 1 удаа	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
		Усалгаа, арчилгаа, тордолт хийх	удаа	8	ҮАЗ-д	-	5-9 сард	
Нийт						1,500,000.00		

**БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2024 оны “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ”-нд тусгах ажлын саналыг Хэнтий аймгийн БОАЖ-ын газрын саналыг үндэслэн тухайн газартай экологийн хувьд төстэй тус сумын нутаг дэвсгэрт дүйцүүлэн хамгаалах газар нутгийг сонгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	

1	Биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх, хамгаалах арга хэмжээ авах	Хэнтий аймгийн БОАЖ-ын газраас ирүүлсэн саналын дагуу дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэх	-	-	4617500	9235000	8 сард 1 удаа	-MNS 5916:2008 -MNS 5917:2008 -БОНХСайдын 2015 оны А-138 тоот тушаал
2	Өмнөх онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд мониторинг хийх, хаягжуулах	Дүйцүүлэн хамгаалал хийсэн талбай	1	120 000	120 000	8 сард 1 удаа		
Нийт зардал /төг/					9,355,000.00			

БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн барилга байгууламж барих, хаягдлын далан байгуулах явцад үйлдвэрийн эзэмшлийн талбайгаас түүх, соёлын дурсгалт олдворууд илрээгүй боловч төслийн үйл ажиллагааны үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоон энэ тухай орон нутгийн Засаг дарга, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

БҮЛЭГ X. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн боловсруулалтын үйл ажиллагаанд химийн бодисыг ашигладаг тул химийн бодисоос эрсдэл үүснэ. Гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгалаа.

Хүснэгт 12. Болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8

Ажлын байранд гарч болзошгүй гэнэтийн осол аваар	Ажилчдын амь насанд учруулж болох осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бүх ажилчдыг хамгаалалтын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйлдвэрийн бүх цех, хэсгүүд	2	ҮАЗ-д	-	Хавар намрын улиралд 2 удаа	-Гамшгаас хамгаалах тухай хууль -Галын аюулгүй байдлын тухай хууль -Химийн хорт бодисын тухай хууль -Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
	Баяжуулах үйлдвэрийн ажлын байр тус бүрээр аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулан, удирдлагаар батлуулж, ажилчдын нүдэнд ил харагдахуйц газарт байршуулах	Үйлдвэрийн бүх цех, хэсгүүд	1	ҮАЗ-д	-	6 сард 1 удаа	
	Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах, нөхөн бүрдүүлэлт хийх	Баяжуулах үйлдвэрийн бүс	2	350 000	700 000	7 сард 1 удаа	
	Бүх барилга байгууламжийн доторх цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлгийн угсралт монтажийн бүрэн бүтэн байдалд тогтмол үзлэг шалгалт хийж, засвар үйлчилгээ хийх	Баяжуулах үйлдвэр, кемп	2	ҮАЗ-д	-	6, 9 сард 1 удаа	
	Баяжуулах үйлдвэрийн 2024 оны Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг УУАА-иар батлуулж хэрэгжүүлэх	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	1	ҮАЗ-д	-	6 сард 1 удаа	
Хээрийн болон объектын гал түймэр	Хээрийн болон объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж сургалт зохион байгуулах, галаас хамгаалсан зурвас татах, болзошгүй аюул осол тохиолдоход гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг бэлэн байлгах, нөхөн бүрдүүлэлт хийх	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	1	ҮАЗ-д	-	7-8 сард 1 удаа	

	Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх самбарыг баяжуулах үйлдвэрийн цех хэсгүүдэд байршуулах, галын хорны хяналтын карт хөтлөх, гал хорны тэмдэг тэмдэглээгээг шинэчлэх	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	1	ҮАЗ-д	-	7-8 сард 1 удаа
Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах үйл ажиллагааны горим алдагдсанаас байгаль орчин бохирдох, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Химийн бодис хадгалах агуулах, шинжилгээний өрөөнд эмийн сан болон галын хорыг стандартын дагуу байршуулах	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	2ш	150 000	300000	8 сард 1 удаа
	Химийн бодисын аюулгүй ажиллагааны самбар, тэмдэг тэмдэглээгээг шинээр хийлгэж байршуулах	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	4 ш	50 000	200000	8 сард 1 удаа
	Химийн бодис хадгалах агуулахуудыг засварлаж, стандартын дагуу тохижуулах /агуулах нь тухайн бодисын ХАЛМ-д заасан шингээгч материалаар /зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч гэх.мэт/ хангагдсан байна/	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	-	ҮАЗ-д	-	8 сард 1 удаа
	Химийн хорт бодистой харьцах үеийн өдөр тутмын зааварчилгааг батлуулж, цех хэсгүүдэд байршуулах	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	-	ҮАЗ-д	-	6 сард 1 удаа
	Химийн бодисын зарцуулалтын бүртгэлийг тухай бүр хөтлөх, зарцуулалтын тайланг хугацаанд нь гаргах, дээд байгууллагад тайланг хүүргүүлэх	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	-	ҮАЗ-д	-	Үйлдвэр ажиллах үед 11 сард 1 удаа
	Химийн бодис хадгалах агуулахын хаяг шинээр хийлгэж байршуулах	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	1 ш	50 000	50 000	8 сард 1 удаа

	Үйлдвэрт хэрэглэгдэж буй химийн бодисын хор аюулгүйн лавлах мэдээллийг бодис бүрээр шинэчлэн хийж нүдэнд ил харагдахуйц байршуулах /ажилтан нэг бүр тухайн бодис, хольц, хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх арга зэргийг сайтар уншиж танилцан мөрдөх/	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	15 ш	ҮАЗ-д	-	7 сард 1 удаа
	Аюултай хог хаягдлын агуулахад тэмдэг тэмдэглэгээ хийх, гэрэлтүүлэгтэй болгох, хог хаягдлыг стандартын дагуу хадгалах	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	1ш	ҮАЗ-д	-	7 сард 1 удаа
	Аюултай хог хаягдлаа тээвэрлүүлэх гэрээ байгуулан, хуримтлал үүссэн үед тээвэрлэлт хийлгэх, аюултай хог хаягдлын тайланг хугацаанд нь гаргаж дээд байгууллагад хүргүүлэх	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	-	ҮАЗ-д	-	Хуулийн хугацаанд
	Химийн бодисын болзошгүй осол, аваарын үед ажиллах ослын төлөвлөгөөг боловсруулан орон нутгийн ОБГ-аар батлуулан мөрдөж ажиллана.	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	1	ҮАЗ-д	-	8 сард 1 удаа
Үер усны аюул	Гэнэтийн үер усны аюулаас урьдчилан сэргийлэн үерийн далан хийж суваг шуудуу татах, бүрэн бүтэн байдлыг хянах	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	1	ҮАЗ-д	-	7-8 сард 1 удаа
Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийг ШТС болон ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газарт сурилуулах, цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, холбогдох байгууллагаар ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулах	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	1	ҮАЗ-д	-	7-8 сард 1 удаа

Нийт төсөв /төг/

1250000

БҮЛЭГ XI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалт

Хог хаягдлаа хэрхэн бага ялгаруулах, ангилах, ялгах талаар сургалтыг ажилчдад байгуулна. Уг уурхай нь 80 ажилчидтай байх бөгөөд нэг ажилчнаас хоногт дунджаар 0.3 кг ахуйн хатуу хог хаягдал гарна гэж үзвэл хоногт 24.0 кг, жилд 5.0 тн нийт хаягдал гарна. Уурхай болон баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлыг ангилж ахуйн хогтой хамт түр хадгалах ба орон нутгийн Захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний дагуу тээвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.

Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад химийн хорт бодисын сав баглаа боодлын хаягдал гарна. Технологийн бус, сонор сэрэмжгүй, сахилга хариуцлагагүй үйл ажиллагааны улмаас хаягдлын далан шүүрэх, нефтийн бүтээгдэхүүн алдагдаж, хөрс, ус агаар орчныг бохирдуулах болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг сайтар төлөвлөж ажиллана.

Үйлдвэрийн ашиглалтын ажлын үед ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжүүдэд зохих хуваарийн дагуу техникийн үйлчилгээ хийх үед ажилласан тос, тосолгооны хаягдал материал гарахаар байна.

Үйлдвэрийн суурингаас гарах ахуйн зориулалтаар хэрэглэсэн бохир ус, шингэн хаягдал орчныг бохирдуулах нөлөөтэй.

Хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах арга хэлбэр:

Тус үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагаанаас гарах хаягдлын сангийн хатуу хаягдлыг жилд 1 удаа түрж хаягдлын далангийн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглана.

Үйлдвэрийн гаралтай металл хаягдлыг тусгай талбайд хурааж, тээвэрлэж, 2-догч түүхий эд болгон борлуулах арга хэмжээг авна.

Мөн ажиллагсдын байрлах байрнаас хатуу хог хаягдал гарна. Үүнийгээ гэрээ байгуулан тогтмол хугацаанд хогийн цэгт тээвэрлүүлж, гарсан зардлыг бүрэн барагдуулж ажиллана.

Шингэн хаягдал цэвэрлэгээ, арга хэлбэр, зайлуулалт:

Тус үйлдвэр нь үйлдвэрлэлийн зориулалтаар усыг хэрэглэхдээ эргүүлэн ашиглах процессоор хэрэглэнэ. Ахуйн шингэн хаягдлыг тусгай бэлтгэсэн нүхэнд хаяхын зэрэгцээ бие засах газрыг эрүүл ахуйн талаас нь стандартын шаардлага хангахуйц бетонон доторлогоо хийх, засаж тохижуулж үнэр болон бусад сөрөг нөлөөлөл үүсэхээс урьдчилан сэргийлж байгуулах болно.

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
----------------------	---	-------------------------------	-------------	---------------------	------------	-------------------	---------------------	---------------------------------

1	2	3	4	5	6	7	8	9
1.Ахуйн	Оффисоос гарч буй цаасны хаягдлыг (бүх төрлийн цаасан хайрцаг, короогүй шохойгүй хоол хүнсний бохирдолгүй байх) ангилан хаях	Ажилчдын амралтын бүс	удаа	ҮАЗ-д	Тухай бүр	-	Хуримтлал үүсэх бүрт	-Хог хаягдлын тухай хууль
	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж хогийн сав байршуулах (ажилчдын байрны ойролцоо болон дотор орчинд), хаягжуулах	Ажилчдын амралтын бүс	ш	100000	5	500000	6 сард 1 удаа	
	Уурхайн кемпээс үүсэж болох хуванцар сав баглаа боодлыг (цэвэр ус, ундаа, хоолны хуванцар сав ундааны лааз, тугалган сав гэх мэт) савыг суллан зориулалтын газарт цуглуулж эргүүлэн ашиглах шаардлагатай газарт нийлүүлэх	Ажилчдын амралтын бүс	удаа	ҮАЗ-д	Тухай бүр	-	Хуримтлал үүсэх бүрт	
	Хатуу хог хаягдлыг тусгайлсан төмөр торон хашлагад байршуулах, хаягжуулах	Ажилчдын амралтын бүс	удаа	ҮАЗ-д	Тухай бүр	-	Хуримтлал үүсэх бүрт	
	Тусгай зөвшөөрлийн талбай болон кемпийн орчны хог хаягдлыг цэвэрлэх	Баяжуулах үйлдвэрийн бүс	удаа	ҮАЗ-д	8	-	Сард 2 удаа	
	Ахуйн хог хаягдлыг түр хадгалах цэгт төвлөрүүлэн, тээвэрлэхдээ орон нутгийн Захиргаатай гэрээ байгуулан төвлөрсөн хогийн цэгт нийлүүлэх, хог хаягдлын төлбөрийг тухай бүр төсөвт төвлөрүүлэх	Үйлдвэрийн нөлөөллийн бүс	удаа	ҮАЗ-д	Тухай бүр	-	5 сард 1 удаа	
	2.Үйлдвэрийн	Үйлдвэрийн хатуу хаягдлыг тусгай бэлтгэсэн талбайд төвлөрүүлэн хадгалах	Үйлдвэрийн бүс	-	ҮАЗ-д	-	-	
	Шатах тослох материалын хаягдлыг тусгай цэгт хадгалах, хаягжуулах	Үйлдвэрийн бүс					Хуримтлал үүсэх бүрт	

3. Аюултай	Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, тээвэрлүүлэх гэрээ эрх бүхий байгууллагатай байгуулах	Үйлдвэрийн бүс	удаа	ҮАЗ-д	1	-	6 сард 1 удаа
	Аюултай хог хаягдлын сав баглаа боодлыг ангилан тусгай газарт хадгалах	Үйлдвэрийн бүс					Хаягдал гарах бүрт
Нийт төсөв /мян.төг/						500 000	

БҮЛЭГ XII. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Ханшашир” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм. “Ханшашир” ХХК -ийн Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт орших Дожир далд уурхайн баяжуулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхэд дээрх аргачлалын дагуу “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” -ийг явуулах үүрэгтэй бөгөөд гаргах зардлыг тус компани нь бүрэн хариуцна. Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ-н харьяа БОХЛ, “ХАНЛАБ” ХХК-ийн итгэмжлэгдсэн лаборатори, Геологийн төв лаборатори, Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори болон УСУГ-ын усны лабораторид мөрдөгдөж буй үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.

Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал (төг)	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
Агаарын чанар								
1	Агаар орчны шинжилгээг мэргэжлийн байгууллагын	Агаарын бохирдол: -Нүүрстөрөгчийн исэл CO -Азотын исэл (NO ₂) -Хүхрийн давхар исэл (SO ₂), -Ажилчдын кемп	5, 9 сард	2	130 500	3 пэг х 130500 = 391 500		MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,

	шинжээчээр хийлгэх	-Хаягдлын далан орчинд -Баяжуулах үйлдвэр						MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшиний хэмжээ
2	Тоосжилт Нийт тоос (PM2.5, PM10)	CO, SO ₂ , NO ₂ -Хаягдлын далан, -Дотоод тээврийн зам -ажилчдын тосгон -баяжуулах үйлдвэр	5, 9 сард	2	130500	4 цэг 130500 522 000 1,044.000		
3	Гадаад болон дотоод орчны дуу чимээний түвшин	-Машин механизмын хөдөлгөөн -Үйлдвэрийн бүх цех, хэсгүүдэд -Захиргаа, аж ахуйн байр -Шинжилгээний өрөө	Сард 1 удаа	6	-	4 цэг	Дуу чимээ хэмжигч апп ашиглан ИТА-д хэмжилтийг хийнэ.	
Нийт зардал /төг/						1 305 500		
Хөрсний бохирдол								
2.1	Хөрсний хүнд металлууд /Pb, Cd, Hg, Cr, Zn, Cu, Co, Sr/, SO ₄ , Ca, Mg, Ni, Na, Fe, NO ₃ , pH/	-Хаягдлын далангийн орчимд 1 -Үйлдвэрээс хойш 250 м /фон цэг/ -1 -Баяжуулах үйлдвэр орчимд-1 -Ажилчдын кемп-1	5, 9 сард	2	120 000	4 цэгт х 480 000		MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
	Хөрсний ерөнхий Ялзмаг %, pH, CaCO ₃ , EC _{2.5} , Хөдөлгөөнт фосфор, кали	- хаягдлын далан орчинд -Ажилчдын кемп орчинд	5, 9 сард	2	120000	2 цэгт 240 000		

	Хөрсний эрүүл ахуй /орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактери	Нянгийн тоо Колититр Перфрингесийн таныц -Баяжуулах үйлдвэрийн ажилчдын кемп орчмын хөрс -ОО-ын орчинд	7 сард	1	120 000	2 цэгт 240 000		MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Нийт /төг/					960 000		
Усны хяналт шинжилгээ								
1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Гүний худаг 111 ⁰ 47/13// 47 ⁰ 44/16 (Анионууд: Cl ⁻ , SO ₄ ⁻ , NO ₂ ⁻ , NO ₃ ⁻ , CO ₃ ⁻ , HCO ₃ ⁻ Катионууд: Na ⁺⁺ K ⁺ , Ca ⁺⁺ , Mg ⁺⁺ , NH ₄ ⁺ , Fe ⁺⁺ , Fe ⁺⁺⁺ , рН, ЕС, TDS, Физик чанар: тунгалаг, үнэр, тунадас, өнгө, амт)	5, 9 сард	2 удаа	360 000	2 цэг 720 000		MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
2	Усан дахь нян бактерийн шинжилгээ	-Гүн өрмийн худаг 111 ⁰ 47/13// 47 ⁰ 44/16 -малчны худаг /фон цэг/	7 сард	1	260 000	2 цэг 520000		
3	Хаягдал усны химийн найрлагын шинжилгээ /Al, Cd, Cr, Cu, Fe, Mn, Mo, Pb, As, Hg, WAD, CN, Ni, Ag, Zn/	- Хаягдлын ус //баяжуулах үйлдвэрийн хаягдал ус/	5, 9 сард	2	320 000	1 цэг 640 000		
	Нийт				1,880,000			
Ургамлан нөмрөг								

1	-Ургамлын зүйлийн бүрдэл, -тусгаг бүрхэц, -арвийн үнэлгээ	-Баяжуулах үйлдвэрийн орчинд -Хаягдлын далангаас баруун тийш 250м-т фон цэг	8 сард	1	ҮАЗ-д	2 цэг	Баяжуулах үйлдвэрийн БОМэргэжилтэн судалгааг хийж гүйцэтгэнэ.	-Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхлагдлыг тодорхойлох MNS 5546:2005 -Ургамлын хээрийн судалгааны арга зүй
Амьтны аймаг								
1	Амьтны зүйлийн бүрдэл, тархалт байршлын судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгөх	Төслийн талбай болон түүний ойр орчинд	8 сард	1	ҮАЗ-д	2 цэг	Баяжуулах үйлдвэрийн БОМэргэжилтэн судалгааг хийж гүйцэтгэнэ.	-Амьтны судалгааны арга зүй
Нийт дүн						0		
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 2024 оны зардлын дүн						4 145 000		

БҮЛЭГ XIII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг байгаль орчны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны мэргэжилтэнд хариуцуулан дээж авч шинжлүүлэх, Мэргэжлийн эрх бүхий байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах, үр дүнг тайлагнан, эрх бүхий байгууллагаар батлуулах

- Гал, үер ус, байгалийн бусад гамшгийн аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч, санамж, анхааруулах самбар хийж байрлуулах
- Байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх,
- Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу үйлдвэрийн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ,
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, гал түймэр, салхи, шуурга) болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1 удаа сургаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллана.
- Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх.

Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар	Сар	Сар		
1	2	3	4	5	6	7	
1	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэнг захирлын тушаалаар томилох, байгаль орчны асуудлыг хариуцан ажиллах	Дотоод зардал	2 сар	-	-	Компанийн удирдлагууд	
2	Оролн нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх, хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хүргүүлэх	Дотоод зардал	Тухай бүр	-	-	Компанийн удирдлагууд	
3	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн талаар ажилчдад сургалт зохион байгуулах	Дотоод зардал	Сар бүр	-	-	ХАБЭА-ын ажилтан	
Нийт зардал		0	-				

БҮЛЭГ XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм. Биологийн нөхөн сэргээлтийг орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгөх бөгөөд холбогдох тайлан, төлөвлөгөөг Төрийн захиргааны төв байгууллагаар цаг тухайд нь батлуулан, орон нутгийн иргэдэд тайлагнах ажлыг 10 сард багтаан хийж гүйцэтгэнэ.

“Ханшашир” ХХК-ийн Дожир жоншны хүдрийн ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн Баяжуулах үйлдвэрийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **20,000,000.00 мян.төг** зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 16. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Цахимаар	БОМТ-ний тайлан, дүгнүүлсэн акт, холбогдох бичиг баримтын хамт хүргүүлэх	12-р сарын 30	ҮАЗ-д	БОМэргэжилтэн	БОАЖ-ын яам
Аймгийн БОАЖ-ын газар	Цахимаар	2024 оны БОМТ-ний биелэлтийн тайланг хүргүүлж, ажлын хэсгээр дүгнүүлэх	Хуулийн хугацаанд 11-р сарын 1	ҮАЗ-д	БОМэргэжилтэн	Баяжуулах үйлдвэрт
Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн багийн ИНХурал	Илтгэл хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг хэлэлцүүлэх	9 сард	ҮАЗ-д	Гүйцэтгэх захирал БОМэргэжилтэн	Багийн ИНХ
Орон нутгийн иргэдээс санал, гомдол хүлээн авах	Цаасаар	Орон нутгийн иргэдээс санал гомдол гарсан тохиолдол бүрт гомдлыг барагдуулан, бичгээр биелэлтийг тайлагнаж байх	Тухай бүрд нь	ҮАЗ-д	Компанийн удирдлагууд БОМэргэжилтэн ХАБЭА-ийн ажилтан Хүний нөөцийн мэргэжилтэн	Баяжуулах үйлдвэрт

